

**ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

1997 оны 5 дугаар сарын 06 ны өдөр

Дугаар 4/А-74

Улаанбаатар хот


Протез-ортопедийн үйлчилгээний төв байгуулах тухай

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын зөвлөлийн 1997 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Протез-ортопедийн тасгийг бие даалган 1997 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн “Протез-ортопедийн үйлчилгээний төв” болгон зохион байгуулж, дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Протез-ортопедийн тасаг бие даан ажиллах болсонтой холбогдуулан Гэмтэл согог, сэргээн засалтын клиник эмнэлгийн 1997 оны тосвоос тус төвийн төсвийг салган олгохыг Нийслэлийн санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.
3. Протез-ортопедийн үйлчилгээний төвийн санхүүжилтийн оновчтой механизм тогтоож, үйлчилгээний бус зардлыг бууруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэхийг Протез-ортопедийн үйлчилгээний төвд даалгасугай.
4. “Протез-ортопедийн үйлчилгээний төвийг хөгжүүлэх төсөл” боловсруулах, олон улсын болон гадаадын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахад нь мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Анагаах ухаан, эмнэлгийн хөгжлийн газар /Л.Жамбалжав/, Эдийн засаг, зохицуулалтын газар /Д.Баярсайхан/, Хүн ам, нийгмийн хамгааллын газар /Б.Баясгалан/-т, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ё.Тэрбиш/-т даалгасугай.


 ГЭГЭЭРЛИЙН САЙД БӨГӨӨД
 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
 ХАМГААЛЛЫН САЙДЫН
 ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
 Ч.ЛХАГВАЖАВ


 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
 БӨГӨӨД УЛААНБААТАР
 ХОТЫН ЗАХИРАГЧ
 Ж.НАРАНЦАЦРАЛТ



ПРОТЕЗ-ОРТОПЕДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Протез-ортопедийн үйлчилгээний төв нь /цаашид төв гэнэ/ төрөлхийн согог, өвчин, осол гэмтлийн улмаас тахир дутуу болсон хүнд протез-ортопедийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, дасган сургах, согог гэмтэлтэй бие эрхтэнийг сэргээн засах эмнэлэг-нийгмийн үйлчилгээний мэргэжлийн байгууллага мөн.
2. Төвийн зорилт нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд тахир дутуу хүнд үйлчлэх /шүдний протез, нүдний шил, тэргэнцэр, таяг, сонсголын аппаратын зэрэг/ үйлчилгээг төвлөрүүлэн зохион байгуулах, тахир дутуу хүн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, өөрөө өөртөө үйлчилж сурах, хөдөлмөрлөх чадвартай болоход нь алдагдсан бие эрхтэний үйл ажиллагааг сэргээн засах сургалт явуулах зэргээр протез-ортопедийн үйлчилгээ, сэргээн засах тусламжийг үзүүлэхэд оршино.
3. Төв нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.
4. Төвийн даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдтай зөвшилцөн томилно.
5. Төвийн дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол улсын хууль, тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг зохион байгуулж хангуулна.
6. Төвийн зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх үүрэг бүхий даргын зөвлөл ажиллана. Энэхүү зөвлөлийг төвийн дарга толгойлно. Даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг даргын тушаалаар батална.
7. Төв нь тогтоосон журмаар хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Протез-ортопедийн үйлчилгээний төвийн үүрэг, эрх:

8. Төв нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ тахир дутуу хүнд нутаг дэвсгэрийн харьяаллыг харгалзахгүйгээр протез-ортопедийн хэрэгслээр үйлчлэх, сэргээн засах сургалт явуулах, протез-ортопедийн хэрэгслэлийг аль болохоор дотооддоо үйлдвэрлэж нэр төрлийг олшруулах замаар тахир дутуу хүний хэрэгцээг бүрэн хангах;

б/ төв нь өөртөө харилцах данстай байх бөгөөд нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг улирал, жилээр гаргаж холбогдох байгууллагад өгөх;

в/ эмнэлэг стационарын холбоог улам ойргуулах, Гэмтэл согог, сэргээн засалтын клиник эмнэлэгтэй хамтран ажиллаж, экспресс протез болон сургалтын протезийн үйлчилгээ эрхлэх;

г/ протез-ортопедийн үйлчилгээг хөгжүүлэх, дэвшилтэт техник, технологийг судалж нэвтрүүлэх, түүхий эд материалын импортыг орлуулах талаар ойрын болон хэтийн бодлого чиглэлтэй ажиллах;

д/ өөрийн үйлчилгээний баазад түшиглэн мэргэжлийн боловсон хүчнийг давган сургаж бэлтгэх, протезист эмч, дунд мэргэжилтнийг дотоод, гадаадад урт, богино хугацаагаар сургах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

е/ эмнэлэг болон нийгмийн халамжийн байгууллагатай гэрээгээр ажиллах /нийслэл, аймгийн халамжийн төв, асрамжийн газрын тахир дутуу хүн бусад эмзэг хэсэгт зориулсан хувцас, зөөлөн оёдол болон бусад үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх/, орон нутгийн тахир дутуу иргэдэд захиалгат явуулын үйлчилгээ эрхлэх;

ж/ үйлчилгээг станадартын түвшинд чанартай гүйцэтгэх, бүтээгдэхүүн, протез-ортопедийн үйлчилгээгээр хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах;

з/ ажиллагчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

и/ хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг зөв зохистой бүрдүүлэх, зарцуулах;

к/ Тахир дутуу хүн гадаадад протез хийлгэх асуудлаар холбогдох эмнэлгийн байгууллагатай хамтран дүгнэлт гаргах.

9. Төв нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ протез-ортопедийн болон сэргээн засах үйлчилгээний стандарт, технологийн заавар, журмын үндэслэлийг боловсруулах, холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, тэрчлэн тахир дутуу хүний нийгмийн хамгаалал, үйлчилгээний асуудлаар дээд байгууллагад санал оруулах;

б/ протез-ортопедийн үйлчилгээний бус зардлыг бууруулах, үндсэн үйлчилгээний тоо, чанарт нөлөөлөхгүйгээр ажил, үйлчилгээний хүрээг өргөтгөж төлбөртэй үйлчилгээ нэвтрүүлэх;

в/ ажил, үйлчилгээг хэвийн явуулах, протез-ортопедийн үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, материал, түүхий эд, хэрэгслэлийг харилцан нийлүүлэх асуудлаар дотоод, гадаадын байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулах, хамтран ажиллах;

г/ төвийн дотоод бүтцийг тогтоож батлах, хууль, тогтоомжид нийцүүлэн төрийн өмч, төсөв хөрөнгийг захиран зарцуулах;

д/ Монгол улсын хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдэлнэ.